

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ



2007 оны 11 дүгээр  
сарын 30-ний өдөр

Улаанбаатар хот

### **Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 3.2.3, 3.2.4 дэх заалт тус тус нэмсүгэй.

#### **1/3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт:**

“3.2.3. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 3.2-т заасан эх үүсвэрээр бүрдэж, мөн хуулийн 6.1-д заасан зориулалтаар тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан Засгийн газар бүрдүүлэн зарцуулах төсвийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв гэнэ.”

#### **2/3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:**

“3.2.4. Нийгмийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан эх үүсвэрээр бүрдэж, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу зарцуулагдах тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг нийгмийн даатгалын сангийн төсөв гэнэ.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.2. Монгол Улсын нэгдсэн төсөв нь Монгол Улсын төсөв, орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.”

**3 дугаар зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Д.ЛҮНДЭЭЖАНЦАН**